АГУУЛГА

**БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 3**
1.1. Төслийн танилцуулга ........ 3
1.2. Төслийн хүчин чадал ........ 4
**БҮЛЭГ-2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 5**
**БҮЛЭГ-3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 7**
**БҮЛЭГ-4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 9**
**БҮЛЭГ-5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 12**
**БҮЛЭГ-6. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 14**
**БҮЛЭГ-7. ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ........ 16**
**БҮЛЭГ-8. ДҮГНЭЛТ ........ 18**

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл ........ 3
Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол ........ 3
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 5
Хүснэгт 4. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт ........ 7
Хүснэгт 5. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 9
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 12
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 14
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ........ 16
Хүснэгт 9. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд ........ 16
Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн ........ 16
Хүснэгт 11. Хөрсөн дэх зарим хүнд металын агууламж ........ 16
Хүснэгт 12. Агаарын хэмжилтийн дүн ........ 17
Хүснэгт 13. Гүний худгийн усны унд ахуйн шинжилгээний дүн ........ 17
Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн ........ 18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг /Google earth/ ........ 3
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал ........ 4
Зураг 3. Үйлдвэрийн дотоод замын харагдах байдал ........ 6
Зураг 4. Замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан зураг ........ 6
Зураг 5. Хог хаягдлын цэгийн зураг ........ 6
Зураг 6. Төслийн талбайд мод тарьж буй байдал ........ 7
Зураг 7. "Тэрбум мод"-ны хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж буй үеийн зураг ........ 8

Зураг 8. Эмийн сангийн зураг ........ 9
Зураг 9. Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж буй үеийн зураг 10
Зураг 10. Төслийн талбайд байрлуулсан гал унтраах багаж хэрэгсэл ........ 11
Зураг 11. Төслийн талбайд байрлуулсан хогийн савнууд ........ 13
Зураг 12. Ажилчдын амрах байрны харагдах байдал ........ 15
Зураг 13. Гал унтраах сургалт зохион байгуулж буй үеийн зураг........ 15
Зураг 14. Улсын бүртгэлийн гэрчилгээ........ 19
Зураг 15. Газар эзэмших гэрчилгээ, гэрээ ........ 21
Зураг 16. Гүний худгийн паспорт ........ 23
Зураг 17. Ус ашиглуулах дүгнэлт ........ 25
Зураг 18. Хог хаягдлын гэрээ........ 30
Зураг 19. Шингэн хог хаягдлын гэрээ ........ 34
Зураг 20. Эмнэлгийн үзлэгийн гэрээ ........ 37
Зураг 21. Бетон зуурмаг тээвэрлэх тээврийн хэрэгсэлтэй хувь хүнтэй хамтран ажиллах гэрээ ........ 40
Зураг 22. Галын дүгнэлт........ 44
Зураг 23. Хөрсний шинжилгээний дүн ........ 45
Зураг 24. Усны шинжилгээний дүн ........ 46
Зураг 25. Агаарын шинжилгээний дүн ........ 47
Зураг 26. 2025 оны БОМТ-ний зардлын 50%-ийг байршуулсан баримт ........ 48
Зураг 27. Ажилчдын амрах өрөө тохижуулсан зардлын баримт ........ 49
Зураг 28. Гал унтраах багаж хэрэгсэл авсан зардлын баримт ........ 49
Зураг 29. Хогийн сав, хог хаягдлын цэг байгуулсан зардлын баримт ........ 50
Зураг 30. Эмийн сангийн зардлын баримт........ 50
Зураг 31. Эрүүл мэндийн үзлэгийн зардлын баримт ........ 51
Зураг 32. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөр төлсөн зардлын баримт ........ 51

# БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

"Тунамал хийц" ХХК-ийн "Бетон зуурмагийн үйлдвэр" нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ТЭЦ-4-ийн баруун хойно, "Эрчим Концерн" ХХК-ийн хажууд, 1.23 га талбайд байрлаж байна.

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл*

| № | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | Регистрийн дугаар | Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг |
|---|---|---|---|---|
| 1 | "Тунамал хийц" ХХК | 5115523 | 9011084096 | Улаанбаатар хот Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн байранд, Утас: 91993013 |

*Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол*

| Цэгийн дугаар | Уртраг | Өргөрөг | Цэгийн дугаар | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 106° 47' 35.27" | 47° 53' 49.67" | 14 | 106° 47' 46.94" | 47° 53' 46.89" |
| 2 | 106° 47' 36.07" | 47° 53' 50.12" | 15 | 106° 47' 46.92" | 47° 53' 46.00" |
| 3 | 106° 47' 37.48" | 47° 53' 49.33" | 16 | 106° 47' 44.46" | 47° 53' 45.99" |
| 4 | 106° 47' 39.15" | 47° 53' 48.69" | 17 | 106° 47' 44.27" | 47° 53' 46.26" |
| 5 | 106° 47' 40.23" | 47° 53' 48.35" | 18 | 106° 47' 43.05" | 47° 53' 46.38" |
| 6 | 106° 47' 41.85" | 47° 53' 48.05" | 19 | 106° 47' 43.01" | 47° 53' 46.24" |
| 7 | 106° 47' 43.23" | 47° 53' 47.90" | 20 | 106° 47' 42.01" | 47° 53' 46.39" |
| 8 | 106° 47' 43.98" | 47° 53' 47.86" | 21 | 106° 47' 42.05" | 47° 53' 46.51" |
| 9 | 106° 47' 44.09" | 47° 53' 48.35" | 22 | 106° 47' 41.87" | 47° 53' 46.54" |
| 10 | 106° 47' 43.39" | 47° 53' 52.95" | 23 | 106° 47' 40.33" | 47° 53' 46.86" |
| 11 | 106° 47' 43.76" | 47° 53' 52.76" | 24 | 106° 47' 38.82" | 47° 53' 47.35" |
| 12 | 106° 47' 44.41" | 47° 53' 52.22" | 25 | 106° 47' 37.90" | 47° 53' 47.75" |
| 13 | 106° 47' 44.90" | 47° 53' 46.88" | 26 | 106° 47' 36.44" | 47° 53' 48.60" |

*Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг /Google earth/*



## 1.2. Төслийн хүчин чадал

“Бетон зуурмагийн үйлдвэр” нь Барилга хот байгуулалтын яамны 2023 оны 08 сарын 15 ны өдөр гарсан МҮ 18-066/23 тоот Материалын үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, НМХГ-ын 02-04-190/209 тоот “Химийн бодисын агуулахын дүгнэлттэй, Монгол улсын хэмжээнд мөрдөх MNS 1185:98 стандартын дагуу М100-М450 маркийн бетоныг БНСУ-ын орчин үеийн дэвшилттэй техник тоног төхөөрөмжөөр тоноглогдсон компьютерийн удирдлагаар үйл ажиллагаагаа зохицуулдаг, цагт 120.0 м3 буюу өдөрт 1200.0 м3 бетон зуурмаг үйлдвэрлэх харьцангуй өндөр хүчин чадалтай бөгөөд хамтран ажиллаж буй 6-8 м3 багтаамжтай миксер автомашинаар тээвэрлэн 28-58 метрт хүрэх бетон шахагч автомашиныг /Солонгос/ ашиглан хөнгөн шуурхай бетон нийлүүлтийн үйлчилгээг үзүүлж байна. Бетон зуурмагийг үйлдвэрлэхэд ашиглагдах 1 нэр төрлийн химийн бодисыг ашиглах ба агуулахад нийт 1 ширхэг химийн бодис хадгалах юм. Бетон зуурмагийг үйлдвэрлэхэд ашиглах нэмэлт химийн бодисыг БНСУ-ын “Power Tech Co” ХХК-ын 20240226 тоот гэрээгээр импортлон оруулж ирэх бөгөөд шаардлагатай хэмжээ нь 178.2 тн/жил, нэг удаагийн таталтаар 19.8 тн-ийг авч агуулахад хадгалах юм.

Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал



## БҮЛЭГ-2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал Мян.төг |
|---|---|---|---|
| | **Агаар орчин** | | |
| 3.1 | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Үйлдвэрийн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулж байхаар "Гурван гал" нэгдсэн эмнэлэгтэй Эрүүл мэндийн үзлэг зөвлөгөөнд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. | 6922.1 Гэрээг хавсаргав. Зардлын баримтыг хавсаргав. |
| 3.2 | Машин механизмын дутуу шаталт хөдөлгүүрийн үйл ажиллагаа бүрэн явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж оношилгоо засвар зэргийг байнга хийлгэх шаардлагатай | "Тунамал хийц" ХХК нь өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлтэй хувь хүмүүстэй хамтран ажиллах гэрээ байгуулан үйлдвэрлэсэн бетон зуурмагийг захиалагчдад хүргэж өгдөг бөгөөд тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээг хувь хүн өөрөө хариуцдаг. | Бетон зуурмаг тээвэрлэх тээврийн хэрэгсэл эзэмшдэг хувь хүнтэй хамтран ажиллах гэрээг хавсаргав. |
| 3.3 | Ашиглаж буй шороон зам талбайд усалгаа хийх, замын тэмдэг, тэмдэглэгээ сайжруулах, хурдны хязгаарыг мөрдөн ажиллах | Төслийн талбайн дотоод замыг тогтмол засч, шаардлагатай үед тоосжилт дарах чийгшүүлэлт хийж ажиллаж байна. | Зургийг тусгав. (Зураг.3) |
| | **Хөрс, ургамлан нөмрөг** | | |
| 3.4 | Хөрсийг элэгдэл бохирдлоос хамгаалах, үүднээс орчны замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, засч сэлбэх | Замын тэмдэг тэмдэглэгээг засч сэлбэн стандартын дагуу байршуулсан. | Зургийг тусгав. (Зураг.4) |
| 3.5 | Химийн бодисын сав уутыг хадгалах түр цэгийг байгуулан хадгалах | "Тунамал хийц" ХХК нь бетон зуурмагийн үйлдвэрийн химийн нэмэлтээ "Винмейкер" ХХК-иас гэрээний дагуу худалдан авдаг бөгөөд сав баглаа боодлыг нийлүүлэгч компанид буцаан өгдөг. | --*-- |
| | **Усан орчин** | | |
| 3.6 | Барилга байгууламжийн гадна, дотор талыг тогтмол цэвэрлэж байх | Төслийн гадна, дотно талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байна.<br>Мөн туул голын сав газраас ус ашиглуулах дүгнэлт авсан бөгөөд үйлдвэрийн зориулалтаар ашигласан усны төлбөрийг тогтмол төлж ажиллаж байна. | 789.9 Зардлын баримтыг хавсаргав. |
| | **Нийт** | | **7712.0** |

"Тунамал хийц" ХХК нь одоогийн байдлаар 19 ажилчинтай үйл ажиллагаагаа явуулж байна. 2025 оны 6-р сарын 12-нд "Гурван гал" нэгдсэн эмнэлэгтэй "Эрүүл мэндийн үзлэг зөвлөгөөнд хамтран ажиллах" гэрээ байгуулан ажилчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулсан. /Гэрээг хавсаргав./

Зураг 3. Үйлдвэрийн дотоод замын харагдах байдал




Зураг 4. Замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан зураг



Зураг 5. Хог хаягдлын цэгийн зураг



## БҮЛЭГ-3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал Мян.төг |
|---|---|---|---|
| 4.1 | Талбайд мод тарих, Тарьсан мод бутны арчилгаа, тордолгоог хийх | Төслийн талбайд байрлах оффисын зүүн талын талбайд 15 ш мод суулгаж усалгаа хийсэн. | Зургийг тусгав. (Зураг.6) |
| 4.2 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох. | Бетон зуурмагийн үйлдвэрийн гадна байрлах нийтийн эзэмшлийн талбайд 108ш мод суулгаж усалгаа хийсэн. | Зургийг тусгав. (Зураг.7) |
| Нийт зардал | | | - |

2025 оны үйл ажиллагааныхаа хүрээнд “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн талбай дээрээ 15 ш мод суулгаж, арчилгаа тордолгоог хийж байна.

Зураг 6. Төслийн талбайд мод тарьж буй байдал



"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд үйлдвэрийн хашааны гадна талд нийтийн эзэмшлийн талбайд 108 ш мод суулгасан.

Зураг 7. "Тэрбум мод"-ны хүрээнд нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж буй үеийн зураг



## БҮЛЭГ-4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 5. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал Мян.төг |
|---|---|---|---|
| 5.1 | Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар лабораторийн ажилчдад сургалт зохион байгуулах | Ажилчдад химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар зөвлөмжийг 7 хоног бүр тогтмол өгч ажиллаж байна. | --*-- |
| 5.2 | Ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн олгож байх /витаминжуулсан ундаа, сүү/ | Ажилчдад тогтмол сүү сүүн бүтээгдэхүүн тараан өгч ажиллаж байна. Мөн анхан шатны тусламжийн эмийн санг оффисын өрөөнд байрлуулсан. | 96.85 Зардлын баримтыг хавсаргав. Зургийг тусгав. (Зураг.8) |
| 5.3 | Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах | Үйлдвэрийн ажилчдад дүүргийн онцгой байдлын албатай хамтран гал унтраах, тактикийн сургалт зохион байгуулж ажилласан. | Зургийг тусгав. (Зураг.9) |
| 5.4 | Гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан батлах, гал унтраах хэрэгслийг бүрдлийг хангаж ажиллах | Үйлдвэрийн талбай дээрээ галын хор, галын сарай зэрэг гал унтраах багаж хэрэгслийг байрлуулсан. Хэвийн ажиллаж байна. Мөн галын дүгнэлтийг сунгуулж авсан. | 475.2 Зургийг тусгав. . (Зураг.10) Зардлын баримтыг хавсаргав. |
| 5.5 | Ажилчдад ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, бүртгэл хөтлөх | Ажилчиддаа машин техникийн бүрэн бүтэн байдал хяналт тавьж ажиллах мөн аюулгүй ажилллагааны дүрмийг мөрдөн ажиллахыг зөвлөж үйл ажиллагаагаа явуулж байна. | --*-- |
| | **Нийт** | | **572.05** |

Зураг 8. Эмийн сангийн зураг



Үйлдвэрийн ажилчдад дүүргийн онцгой байдлын албатай хамтран Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гал гарсан үед авах яаралтай арга хэмжээ, галын хорыг хэрхэн ашиглах тухай заавар зөвлөгөө өгч, тактикийн сургалт зохион байгуулж ажилласан.

Зураг 9. Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж буй үеийн зураг



Зураг 10. Төслийн талбайд байрлуулсан гал унтраах багаж хэрэгсэл



# БҮЛЭГ-5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал Мян.төг |
|---|---|---|---|
| 6.1 | Үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлыг эх үүсвэрээс нь эхлэн ангилан ялгалт хийх | Энгийн хог хаягдлын ангилан ялгах хогийн савыг төслийн талбай дээр байрлуулсан. | 4290.0<br>Зургийг тусгав. (Зураг.11)<br>Зардлын баримтыг хавсаргав |
| 6.2 | Хог хаягдлын гэрээ байгуулан зайлуулж ажиллах | "Баянгол шинэ өргөө" ОНӨААТҮГ-тай "хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хураамж төвлөрүүлэхэд хамтран ажиллах гурвалсан гэрээ"-г байгуулан ажиллаж байна. | 48.1<br>Хогний гэрээг хавсаргав.<br>Хогний төлбөр төлсөн баримтыг хавсаргав. |
| 6.3 | Хог хаягдал түр хадгалах цэгийг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах | Хог хаягдлын түр хураах цэгийн талбайг хатуу хучилттай болгож зассан байна. | Зургийг тусгав. (Зураг.11) |
| 6.4 | Төмрийн хаягдал гарсан тохиодолд ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | 2025 оны үйл ажиллагаанаас төмрийн хаягдал үүсээгүй. | --*-- |
| 6.5 | Сав баглаа боодол нь гэмтсэн тос, тослох материалын хаягдал гарсан тохиолдолд тусгай саванд цуглуулж тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид нийлүүлэх | Төслийн талбай дээрээ хаягдал тос цуглуулах хаягдал тосны сарай байрлуулан түр хурааж байна. | Зургийг тусгав. (Зураг.11) |
| | Нийт | | **4338.1** |

Бетон зуурмагийн үйлдвэрийн талбай дээрх хог хаягдал хураах цэгийг шинэжилж, хогийн савны доорх хэсгийг хатуу хучилттай болгож, ангилан ялгах хогийн сав байрлуулсан. Мөн хаягдал тос түр хадгалах савтай болсон.

Зураг 11. Төслийн талбайд байрлуулсан хогийн савнууд



## БҮЛЭГ-6. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал Мян.төг |
|---|---|---|---|
| 7.1 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн ажилчдын амрах, ая тухтай байдлыг хангах үүднээс ажилчдын амрах байрыг засч тохижууллаа. | 11000.0<br>(Зураг.12)<br>Зардлын баримтыг хавсаргав. |
| 7.2 | Гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаар хийх | Үйлдвэрийн ажилчдад дүүргийн онцгой байдлын албатай хамтран Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай, гал гарсан үед авах яаралтай арга хэмжээ, галын хорыг хэрхэн ашиглах тухай заавар зөвлөгөө өгч тактикийн сургалт зохион байгуулж ажилласан. | Зургийг тусгав.<br>(Зураг.12) |
| 7.3 | Шаардлагатай бичиг баримтын бүрдлийг бүрдүүлж ажиллах | 2025 оны үйл ажиллагааны хүрээнд дараах бичиг баримтыг бүрдүүллээ<br>1. Энгийн хог хаягдал зайуулах гэрээ байгуулсан<br>2. Шингэн хог хаягдал зайлуулах гэрээ байгуулсан<br>3. Туул голын сав газраас ус ашиглуулах дүгнэлт авсан.<br>4. Галын дүгнэлт гаргуулсан<br>5. Газар эзэмших гэрээг шинэчилж хийсэн | Хавсралтад хавсаргав. |
| 7.4 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулж, дүгнүүлэх | Батлагдсан БОННҮ-ний тайлангийн хүрээнд 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж зардлын 50%-ийг БГД-ийн Байгаль орчныг хамгаалах төрийн санд байршуулсан. | 3473.75<br>Зардлын баримтыг хавсаргав. |
| | Нийт | | **14473.75** |

Зураг 12. Ажилчдын амрах байрны харагдах байдал



Зураг 13. Гал унтраах сургалт зохион байгуулж буй үеийн зураг



## БҮЛЭГ-7. ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

*Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал /мян.төг/ | Тайлбар, зураг |
|---|---|---|---|
| 8.1 | Хөрсөн бүрхэвчид хөрсний ерөнхий үзүүлэлт, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн | 58.3 | Хөрсний шинжилгээний дүнг хавсаргав. |
| 8.2 | Агаарын чанар, дуу чимээний шинжилгээ, хэмжилт хийлгэсэн | 60.0 | Агаарын шинжилгээний дүнг хавсаргав. |
| 8.3 | Гүний худгийн усны чанарт шинжилгээ хийлгэсэн эсэх | 49.0 | Усны шинжилгээний дүн хавсаргав. |
| | Нийт | 167.3 | |

**Хөрсний шинжилгээний үр дүн:**

"Бетон зуурмагийн үйлдвэр"-ийн талбайн 1 цэгээс дээж авч "Инженер геодези" ХХК-ийн хөрсний лабораторит шинжлүүлэв.

*Хүснэгт 9. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд*

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ,d sm | Ялзмаг % | $CaCO_2$, % | $NO_3$, мг/ 100г | Солилцох суурь, мг-экв/100гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 1 | - | 8.81 | 0.07 | 0.153 | 0.86 | 0.16 | 0.31 | 10.1 | 6.2 | 2.3 | 7 |

Хөрсний холимог дээжийн химийн найрлагын хувьд урвалын орчин хүчтэй шүлтлэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсгүй, ялзмаг агууламж өнгөн үе давхаргадаа 0.86% буюу бага, үржил шимийн хувьд 100г хөрсөнд хөдөлгөөнт фосфор 2.3 мг буюу бага, хөдөлгөөнт кали 17 мг буюу бага хангагдсан хөрс байна.

*Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн*

| Дээж-ний дугаар | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | - | 41.4 | 32.3 | 9.0 | 5.0 | 8.5 | 3.8 | 17.3 |

Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, 0.01мм ээс бага диаметртэй физик шаврын хэмжээ 17.3 % байна.

*Хүснэгт 11. Хөрсөн дэх зарим хүнд металын агууламж*

| Дээжний дугаар | Дээж авсан гүн, см | Хүнд металлын агууламж, мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Cr /Хром/ | Pb /Хар тугалга/ | Cd /Кадми/ | Zn /Цайр/ | Cu /Зэс/ | Ni /Никель/ |
| 1 | - | 1.62 | - | - | 40.68 | 2.66 | 12.97 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/ | | | | | | | |
| **Хүлцэх агууламж /MNS 5850:2019/** | | **150** | **100** | **3** | **300** | **150** | **150** |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | 400 | 500 | 10 | 600 | 400 | 1000 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | 1500 | 1200 | 20 | 1000 | 1500 | 1800 |

Хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг /MNS ISO 11466:2007/атом шингээлтийн спектрометрээр шинжилж MNS 5850:2019 стандарттай харьцуулахад хөрсний дээжинд цайр 40.68 мг/кг, зэс 2.66 мг/кг, хром 1.62 мг/кг, никель 12.97 мг/кг, агуулагдаж байна. Хар тугалга кадми илрээгүй байна.

Шинжилгээний хариунаас харахад хөрсөн агуулагдаж буй хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

**Агаарын шинжилгээний дүн:**

Бетон зуурмагийн үйлдвэр"-ийн талбайд "Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатор"-т агаарын шинжилгээ хийлгэсэн.

*Хүснэгт 12. Агаарын хэмжилтийн дүн*

| Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Мг/м³ | | | ДБА |
| Гадна талбайн | 2025-05-02 | 09:20 | 0.010 | 0.082 | 0.453 | 44 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 | | | 0.450 | 0.200 | 0.500 | 60 |

Агаарын хэмжилтийн дүнгээс харахад Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

**Усны шинжилгээний дүн:**

Доорх хүснэгтэд гүний худгийн усны унд ахуйн шинжилгээний дүнг орууллаа.

*Хүснэгт 13. Гүний худгийн усны унд ахуйн шинжилгээний дүн*

| Анион | 1 дм³ | | | Катион | 1 дм³ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Мг | Мг-экв | Мг-экв/ % | | Мг | Мг-экв | Мг-экв/ % |
| $Cl^-$ | 47.9 | 1.35 | 23.1 | $Na^+ + K^+$ | 47.0 | 2.04 | 34.9 |
| $SO_4^-$ | 95.0 | 1.98 | 33.8 | $Ca^{++}$ | 61.1 | 3.05 | 52.1 |
| $NO2^-$ | 0.01 | 0.0 | 0.0 | $Mg^{++}$ | 9.1 | 0.75 | 12.8 |
| $NO_3^-$ | 14.0 | 0.23 | 3.9 | $NH_4^+$ | 0.15 | 0.01 | 0.1 |
| $CO_3^-$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.00 |
| $HCO_3^-$ | 140.3 | 2.30 | 39.3 | $Fe^{+++}$ | 0.005 | 0.00 | 0.00 |
| **Дүн** | **297.2** | **5.86** | **100.0** | **Дүн** | **117.5** | **5.86** | **100.0** |

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна.

# БҮЛЭГ-8. ДҮГНЭЛТ

2025 онд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд үзүүллээ.

*Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн дүн*

| № | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Нийт зардал, мян.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 7712.0 |
| 2 | Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт | --*-- |
| 3 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | 572.05 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 4338.1 |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг биелэлт | 167.3 |
| 6 | Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт | 14473.75 |
| **НИЙТ** | | **27263.2** |

## ДҮГНЭЛТ

"Тунамал хийц" ХХК нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт "Бетон зуурмагийн үйлдвэр" -ын үйл ажиллагааг 2025 онд үргэлжлүүлэн ажиллаж нийт 27263.2 мян.төгрөгийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах үйл ажилллагаанд зарцуулсныг тайлагнав.

Зураг 14. Улсын бүртгэлийн гэрчилгээ



Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000159081

2007.02.01
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011084096
/ Хувийн хэргийн дугаар /

5115523
/ Регистрийн дугаар /

Тунамалхийц Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2007.02.01 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 2395 | Барилгын бетон зуурмагийн үйлдвэрлэл |
| 2396 | Барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа |
| 4610 | Гадаад худалдаа |

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 2 | 70,900.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сонгинохайрхан, 15-р хороо, өнөр хорсолол, 19, 78, Утас1: 91990042, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 3 сар 7 өдөр

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Батбилэг овогтой Машбаяр-г Захирал-р томилсныг бүртгэв. | 2012.04.24 | Ч.Мөнгөншагай |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2018.03.07 | Э.Эрдэнэбилэг |
| 3 | Улаанбаатар, Баянгол, 20-р хороо, үйлдвэрийн бүс, 3 тоот Утас1: 91990042, Утас2: 91993013, Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2023.10.09 | Б.Алтансух |
| 4 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 500000 мян.төг-р нэмэгдэж нийт 570900 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2023.10.09 | Б.Алтансух |
| 3 | Улаанбаатар, Баянгол, 20-р хороо, үйлдвэрийн бүс, 3 тоот Утас1: 91990042, Утас2: 91993013, Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2023.10.09 | Б.Алтансух |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*0001590 81*

Зураг 15. Газар эзэмших гэрчилгээ, гэрээ

МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар: 0000098055**

Тунамалхийц ХХК — 5115523

*(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)* *(регистрийн дугаар)*

Нийслэлийн Засаг даргын захирамж 20 22 оны 06 сарын 27 өдрийн А/863 тоот

*(шийдвэр гаргагч)*

шийдвэрийг үндэслэн Улаанбаатар Баянгол 20-р хороо

*(аймаг, нийслэл)* *(сум, дүүрэг)* *(баг, хороо)*

Үйлдвэрийн баруун бүс-3 ______ хаягт

*(гудамжны нэр)* *(хашааны дугаар)*

байрлах, нэгж талбарын 1681910385 дугаар бүхий 12360 м.кв газрыг

Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-2205002796

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

**Хэвлэсэн огноо: 2022-07-05**

Нэгж талбарын дугаар: **1681910385**
Улсын бүртгэлийн дугаар: **Э-2205002796**
Гэрчилгээний дугаар: **0000098055**

# ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

**2025** оны **5** сарын **23** өдөр №**01107-2022/00402** **Улаанбаатар** аймаг/хот **Баянгол** сум/дүүрэг

## Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, **Улаанбаатар** аймаг /нийслэл/-ийн **Баянгол** дүүрэг /сум/-ын Нийслэлийн Засаг даргын захирамж **2022** оны **06** сарын **27** -ны өдрийн **01107-А/863/2022** тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, **Улаанбаатар** аймаг/хотын **Баянгол** сум/дүүргийн Газрын алба, газар эзэмшигчийг төлөөлж **Тунамалхийц ХХК-ны Захирал Б овогтой Машбаяр** нар энэхүү гэрээг байгуулав.

## Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ **12360 м2**

Үүнээс:

| **Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт** | **Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ** | **Газар эзэмших хугацаа** |
|---|---|---|
| Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар | 12360 м2 | 15 жил |

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөр нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

Зураг 16. Гүний худгийн паспорт



**Паспортыг хөтлөх журам**

1. Паспортыг эхлээд анхааралтай уншиж судал;

2. Ашиглалтанд хүлээж авсан өрөмдмөл худаг нь эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэгдэх тусгай зориулалттай байгууламж учир худгийг гаргасантай болон ашиглалттай холбогдсон явцыг харуулсан техникийн паспортой байна.

3. Өрөмдмөл худгийн паспортын анхны бичилтийг худаг гаргасан аж ахуйн нэгж хийж аймаг, нийслэлийн Байгаль орчны албаар баталгаажуулан худаг эзэмшигчид хүлээлгэн өгнө. Паспортыг худаг гаргаж, шавхалт туршилт хийж, ашиглах боломжтой болгож ашиглалтад хүлээж авсан үеэс эхлэн хөтөлнө.

4. Худаг эзэмшигч нь худгаас гарган авч буй усны хэмжээг (насосыг) ажиллуулах бүрт тодорхойлж, улирал бүрээр тэмдэглэлийг үнэн зөв хөтөлнө.

5. Өрөмдмөл худаг бүр мэдээллийн сангийн код болон улсын дугаартай байна.
Худгийн код болон улсын дугаарыг харъяа аймаг, нийслэлийн Байгаль орчны алба олгоно.

6. Усны барилга байгууламжийн паспортыг уг байгууламжийг эзэмшин ашиглагч иргэн, эсвэл аж ахуйн нэгж байгууллагын усны асуудал хариуцсан албан хаагч хариуцан хадгална.

7. Худгийн усыг борлуулсны орлогыг улирал бүрээр улирлын эцэст нэг удаа бөглөх.

Үзэг №. 2005379
УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Төрөл [illegible] худаг
2008 оны 6-р сарын 13-ны өдөр
БҮРТГЭСЭН [illegible]

3



Сум, дүүрэг, хороо . УБ хот БГД 20р хороо
Эзэмшигч иргэн, байгууллагын нэр . "Тунамал хийц" ХХК
Өрөмдмөл худгийн нэр . Тэц-4-н баруун тал . . .

Улсын № 2005379

Байршиж буй газрын нэр, хаяг . Тэц-4-н баруун тал

. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . .

Ус ашиглах гэрээний №

Ус ашиглах эрхийн бичгийн №

Худаг гаргасан (аж ахуйн нэгж) "Эй Ди Ай Ди" ХХК

ЭЙ ДИ АЙ ДИ ХХК тамга
УЛААНБААТАР ХОТ

Захирал Б. [illegible] /Б. [illegible]/

2008 он 5 сар 15 өдөр

Баталгаажуулсан:

[illegible] аймаг(нийслэл)-ын Байгаль орчны албаны

тамга Дарга . . . . . . . . . . . . .

20 [illegible] он [illegible] сар 19 өдөр

4

**Худгийн байршлын солбицол**

Уртраг: 47°53'47,7"N
Өргөрөг: 106°47'42,3"E
Үнэмлэхүй өндөр . . . . . . . . . м;

| Аймгийн код | Сумын код | Худгийн зориулалтын код |
|---|---|---|
| 20 | 05 | 379 |

Улаанбаатар хот аймгийн, хотын . БГ дүүрэг сумын, дүүргийн, хорооны, багийн . 20р хороо . . . . . . гэдэг газарт, . . . . . үйлдвэрийн . . . . . -д зориулан (усжуулалт, ус хангамж г.м) . Улаанбаатар хот . аймгийн, (хотын) "Эй Ди Ай Ди" ХХК компаний . Ш.[illegible] менежер ахлагчтай анги, бригад . . . . . УКС-22 . . . . маркийн станокоор . . . . . цохилт . . . . . . . . . аргаар уул худгийн цооногийг 2008 он 4. сарын 01 өдрөөс 2008 он 4 сарын . 15 . өдөр хүртэл өрөмдөж гаргав.

5

## I. ЦООНОГИЙН БҮТЭЦ ЗОХИОМЖ

1. Цооногийн гүн ........ 30 м
2. Усны тогтсон түвшин (статик) ........ 4,30 м
3. Цооногийн ашиглалтын усны ундарга ........ 1,66 л/с 1/1/ф-
4. Цооногийг өрөмдсөн диаметр:

00 м-ээс 6 м хүртэл 426 мм

6 м-ээс 25 м хүртэл 325 мм

25 м-ээс 30 м хүртэл 219 мм

(Тамга: ТОП ДРИЛЛИНГ ХХК ... УЛААНБААТАР ...)

5. Уст үеийн байрлал:

Нэгдүгээр үе ... 4.30 м-ээс 25 м

Хоёрдугаар үе ... – м-ээс – м

Гуравдугаар үе ... – м-ээс – м

6. Цооногийг бэхэлсэн суултын яндан:

диаметр = 426 мм 00 м-ээс 6 м

диаметр = 325 мм 00 м-ээс 25 м

диаметр = 219 мм 00 м-ээс 30 м

7. Шүүрийн хийц зохиомж:

Шүүрийн яндангийн нүхний диаметр ........ – мм

1 уртааш м-т оногдох нүхний тоо ........ – ширхэг

Шүүрийн диаметр ........ 219 мм

Шүүрийг ороосон утасны диаметр ........ 2.0 мм

Шүүрийг ороосон торны ........ –

Шүүрийн яндангийн нийт урт ........ 30 м

6

Үүнд:

Шүүрийн дээд хэсгийн урт 00 м, 7 м-ээс 7 м

Ажлын хэсгийн урт 7 м, 25 м-ээс 18 м

Дүлий хэсгийн урт – м, – м-ээс – м

Ажлын хэсгийн урт – м, – м-ээс – м

Дүлий хэсгийн урт ... м, ... м-ээс ... м

Тунгаагчийн урт 25 м, 30 м-ээс 5 м

8. Яндангийн араар дүүргэсэн хайрга 3 м³ хайрга хийв.

9. Цооногт ........ м-ээс ........ м хүртэл

........ м-ээс ........ м хүртэл

цементаж (тампонаж) хийв.

10. Шавхалтыг 2008 он 04 сарын 15 өдрийн 17⁰⁰ цагаас 04 сарын 16 өдрийн 17⁰⁰ цаг хүртэл 24 цаг хийв.

Шавхалтыг ... ЭЦВ ... маркын насосоор ........ 29 м

гүнд насосыг суулгаж ........ – ........ маркын

компрессороор ........ – м ус өргүүр яндang ........ – м

гүнд суулгаж ........ – м хий дамжуулах яндang ........ – м,

усны түвшин хэмжигч яндang ........ – м

гүнд тус тус суулгаж гүйцэтгэв.

Шавхалт хийхэд усны

I. түвшин бууралт 3,80 метрт ундарга 11,0 л/с

II. түвшин бууралт – метрт ундарга – л/с

III. түвшин бууралт – метрт ундарга – л/с

тус тус байв.

7

## II. ЦООНОГИЙН ЗҮСЭЛТ

| Масштаб см:м | Үеийн ул хүртэлх гүн (м) | Геологийн зүсэлт | Чулуулгийн бичлэг, геологийн насны индекс | Хийц зохиомж: Суултын шүүрийн яндангийн байрлал | Хийц зохиомж: Суулгасан гүн, м |
|---|---|---|---|---|---|
| 3 | | | шорвогтой хайрга | | |
| 6 | 5.0 | | | | 426 мм 6.0 м |
| 9 | | | | | |
| 12 | | | Гүн бүдүүн | | |
| 15 | | | хайрга | | |
| 18 | | | сайрга элсэн | | |
| 21 | | | дүүргэгчтэй үе | | |
| 24 | 25.0 | | | | 325 мм 25.0 м |
| 27 | | | шавргатай | | |
| 30 | 30.0 | | үе | | 219 мм 30.0 м |
| – | шүүрийн дүүргэлт 219 мм-н ган бөглөөгөөр хийсэн. | | | | |
| | | | | | |
| | | | | | |

8

## III. ЦООНОГИЙН УСНЫ ЧАНАР

1. Шинжилгээ хийсэн он, сар, өдөр

| Үзүүлэлтүүд | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|
| | № ........ м | № ........ м | № ........ м |
| Дээж авсан | | | |
| Лабораторт өгсөн | | | |

2. Физикийн шинж чанар:

| Үзүүлэлтүүд | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|
| | № ........ м | № ........ м | № ........ м |
| Өнгө | | | |
| Үнэр | | | |
| Амт | | | |
| Тунгалаг чанар | | | |
| Тунадас | | | |
| Булингар | | | |
| Температур C° | | | |

3. Химийн найрлага:

| Үзүүлэлтүүд | Нэгж хэмжээ | Уст үеийн № ба интервал | | |
|---|---|---|---|---|
| | | № ... м | № ... м | № ... м |
| PH (идэвхт урвал) | | | | |
| $CO_2$ (чөлөөт) | мг/л | | | |
| $CO_2$ (түрэмгий) | " | | | |
| $H_2S$ (хүхэрт ус төрөгч) | " | | | |
| $SiO_2$ (цахиурын хоёрт исэл) | " | | | |
| Исэлдэх чанар $O_2$ | " | | | |
| Хуурай үлдэгдэл 180°C | " | | | |
| Ерөнхий хатуу | мг. экв/л | | | |
| Арилах хатуу | " | | | |
| Тогтмол хатуу | " | | | |

9

Зураг 17. Ус ашиглуулах дүгнэлт

Туул голын сав газар

# УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 05 -р
сарын 28 -ны өдөр

Дугаар E-2505-000236

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар**

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Тунамалхийц ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 5115523 |
| Захирал: | Машбаяр |
| Холбоо барих дугаар: | 91990042 |
| Факс : | |
| И-мэйл хаяг : | |

**2.Төслийн нэр байршил**

| | |
|---|---|
| Төслийн нэр: | бетон зуурмагийн үйлдвэр |
| Байршил: | Улаанбаатар, Баянгол, 20-р хороо |
| Харьяалагдах сав газар: | Туул голын сав газар |
| Хамаарах салбар: | Барилга |
| Төслийн дэлгэрэнгүй: | - |

**3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр**

Тунамалхийц

**4. Ажиллах горим, хүчин чадал**

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчидын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 7 | 1 ээлжээр | 180 | 20 | 8 |

**5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ**

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 20.0 | ажиллагч | Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцов. - /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 14 дүгээр хавсралт/. |

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| | | | - 1 ажилтан зарцуулах усны хэмжээ - 80 л;<br>2025 оны үйлдвэрийн ажилчдын усны хэрэглээг урьдчилан тооцоход:<br>- Үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны хэрэглээ:<br>20 хүн x 80 л/хүн x 180 хон = 288.00 м3/жил. /Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэв/. |
| Бетон зуурмагийн үйлдвэр | 233.333 | м3 | Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дугээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцов.<br>- /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 6 дугаар хавсралт/.<br>- 1 м3 бетон зуурмаг үйлдвэрлэхэд зарцуулах усны хэмжээ - 0.3 м3;<br>2025 онд ашиглах үйлдвэрийн усны хэрэглээг урьдчилан тооцоход:<br>- Бетон зуурмаг үйлдвэрлэхэд шаардагдах усны хэрэглээ:<br>41'999.94 м3 x 0.3 м3 = 12'599.982 м3/жил /Үйлдвэрийн 2024 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэв/. |

### 6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

| Эх үүсвэр | Зориулалт | Усны нөөц (л) | Усны нөөц (м3) | Тайлбар |
|---|---|---|---|---|
| Гүний худаг | Технологийн хэрэгцээнд | 11.0 | 950.4 | Худагт Стандарт, хэмжил зүйн газраас 2024 оны 02 дугаар сард суурилуулсан LXGS-100 загварын, 100 мм-ийн голчтой, 1408004064 дугаартай усны тоолуур суурилуулсан. 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн тоолуурын заалт: 116342 м3.<br>- Тоолуурын хэвийн ажиллагааг хангаж, заалтын тэмдэглэгээг тогтмол хөтөлж, баталгаажуулах шаардлагатай. |

### 7.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

| | |
|---|---|
| Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : | **Озем инвайрментал ХХК** |
| Холбоо барих : | **88098056** |
| Нэмэлт мэдээлэл: | |

### 8. Усны барилга байгууламжууд

| Барилга байгууламж | Хүчин чадал (м3) | Хэмжээ хийц |
|---|---|---|
| Гүний худаг | 950.4 | - Үйлдвэрийн ус хангамжийн зориулалтаар гаргасан 1 гүний худгаас өөр усны барилга байгууламж ашигладаггүй. |

### 9. Дамжуулах байгууламж

| Хаанаас (эхлэх цэг) | Хаана хүртэл (төгсгөлийн цэг) | Шугамын голч, мм | Дамжуулах шугамын урт, м |
|---|---|---|---|
| Гүний худаг | | 50 | 50 |

### 10. Онцгой нөхцөл

**Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглох;**

**- "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаас давсан бохирдолтой хаягдал усыг төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн тохиолдолд Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах нөхцөл үүсэхийг анхаарах;**

**- Ус хангамжийн худгаас улирал бүр дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж, "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох, шинжилгээний дүнг тайланд хавсаргаж Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.**

### 11. Усны зарцуулалт

| Ажлын нэр | Тоо Хэмжээ | Хэмжих нэгж | Усны хэрэглээ, м3 (Норм) | Гүйцэтгэх давтамж | Хэмжих нэгж | Нийт ашиглах усны хэмжээ, м3 | Хөнгөлөх усны хэмжээ м3 | Төлбөр тооцох усны хэмжээ м3 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 20 | ажиллагч | 0.08 | 180.0 | Хоног | 288.00 | 0.00 | 288.00 |
| Бетон зуурмагийн үйлдвэр | 233 | м3 | 0.3 | 180.0 | Хоног | 12,599.98 | 0.00 | 12,599.98 |
| **Нийт** | | | | | | **12,887.98** | **0.00** | **12,887.98** |

### 12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

| Ажлын нэр | Төлбөр тооцох усны хэмжээ, м3 | Усны ангилал | Хөнгөлөх хувь хэмжээ, % | 1 м3 усны үнэ | Усны нөөц ашигласны төлбөр, ₮ | Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮ | Төлбөл зохих дүн, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах | 288.00 | Газрын доорх ус | 0.0 | 99.12 | 28,546.56 | 0.0 | 28,546.56 |

| Ажлын нэр | Төлбөр тооцох усны хэмжээ, м3 | Усны ангилал | Хөнгөлөх хувь хэмжээ, % | 1 м3 усны үнэ | Усны нөөц ашигласны төлбөр, ₮ | Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮ | Төлбөл зохих дүн, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| усны хэмжээ | | | | | | | |
| Бетон зуурмагийн үйлдвэр | 12599.98 | Газрын доорх ус | 0.0 | 188.80 | 2,378,876.60 | 0.0 | 2,378,876.60 |
| **Нийт** | **12,887.98** | | | | **2,407,423.16** | | **2,407,423.16** |

**13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар**

- Бетон зуурмагийн үйлдвэрүүдэд тавигдаж байгаа шаардлага, зөвлөмжийн дагуу эргэлтийн усан санг байгуулан ажиллаж байна.

**14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө**

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтад заасны дагуу Нийслэлийн Байгаль орчны газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллах шаардлагатай;
- Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтын дагуу ус авах цэг, газрын доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах;
- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 6.5-р заалтын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2 дахь заалтад заасны дагуу тухайн дүүргийн Татварын хэлтэст төвлөрүүлэх шаардлагатай;
-Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18 дахь заалтын дагуу ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно;
- Гэрээнд зааснаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцохыг анхаарах;
- Усны тоолуурын заалтын баталгаа алдагдсан, тоолуурыг шугам хоолойноос салгасан, тоолуургүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын Сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцож ногдуулахыг анхаарах;
- Ус ашиглуулах дүгнэлтээр ногдуулсан усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг хугацаанд нь төлөхгүй үйл ажиллагаа явуулбал Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15 дахь заалтын дагуу хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарч ажиллах;
- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтад заасны дагуу сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тайланг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлж ажиллах;
- Үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар зогсолт хийсэн, эргэн ажиллах тухай бүрд холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж оруулах;
- Ус ашиглуулах дүгнэлт болон хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний хагас жилд багтаан жил бүр гаргуулж байхыг анхаарах.

**Боловсруулсан:**

| | |
|---|---|
| ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗАР | **Уранчимэг** |
| Боловсруулсан огноо: | **2025.05.21** |

Зураг 18. Хог хаягдлын гэрээ

| | | |
|---|---|---|
| БАТЛАВ | БАТЛАВ | БАТЛАВ |
| БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА | БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | Тунамал хийц ХХК ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР |
| /........................../ | /Г.ДАВААСҮРЭН/ | /........................../ |

**ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХЭД ХАМТРАН АЖИЛЛАХ ГУРВАЛСАН ГЭРЭЭ**

2025 оны 05 сарын 19-ны өдөр №25/233 Улаанбаатар хот

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 **Нэг талаас:** Баянгол дүүргийн 20 дугаар хороо, 5675162 тоот регистрийн дугаартай "БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ" ОНӨААТҮГ /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, Баянгол дүүргийн 20 дугаар хороо /цаашид "Засаг дарга" гэх/,
**Нөгөө талаас:** 5115523 тоот регистрийн дугаартай, Баянгол дүүргийн 20 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Бетон зуурмаг чиглэлээр ........ нэртэйгээр үйл ажиллагаа явуулдаг Тунамал хийц ХХК (иргэн эсвэл аж ахуйн нэгж байгууллага) /цаашид "Захиалагч" гэх/ нар доорх нөхцлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээ нь 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс 2027 оны 05 дугаар сарын 19-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаанд энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн дагуу Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, гэр хорооллын иргэн, аж ахуйн нэгж байгууллага /цаашид "байгууллага" гэх/-ын ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр /цаашид "хураамж" гэх/ тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.4 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.

1.5 Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолд заасан тарифын дагуу гэрээний үнийн дүнг тогтоосон болно.

**Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

2.1 Гүйцэтгэгч нь тогтоосон хуваарийн дагуу иргэн, байгууллага, орон сууцны бункерийн ахуйн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэх;

2.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол хуваарьт заасанаас бусад цагаар зохион байгуулалт хийж хог ачуулах арга хэмжээг авна.

2.3 Гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, нэмэлтээр барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, байгууллагын хог хаягдлын хураамж төлөгдсөний дараа тээвэрлэнэ.

2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

2.5 Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

2.6 Гэрээнд заасан хугацаанд хог хаягдлын хураамжийг төлж барагдуулаагүй иргэн, байгууллагын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.

2.7 Хог хаягдлын тухай хуульд заасан зөрчил гаргасан иргэн, байгууллагыг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж хариуцлага тооцуулах эрхтэй.
2.8 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

**Гурав. Захиалагчийн эрх, үүрэг**

3.1 Захиалагч тал "Хог хаягдлын тухай" хуулийг мөрдөж ажиллана.
3.2 Иргэн, байгууллага нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх;
3.3 Энхтайваны өргөн чөлөө, Энэбишийн өргөн чөлөө, Ард Аюуш, Занабазар, Амарсанаагийн гудамжуудын дагуух Аж ахуйн нэгжүүд хүчин чадалдаа нийцсэн HDPE материалаар хийгдсэн 240, 600 литрийн стандарт хогийн савтай байх;
3.4 Тээвэрлүүлэх хог хаягдлыг зөвхөн тогтоосон хог ачилтын цэг, бункерт хийх, ачилт хийхэд саадгүй байхаар орц, гарцыг төлөвлөсөн байх бөгөөд хог ачилт хийхийн өмнө хог ачилтын цэг, бункерийн орц, гарцыг чөлөөлсөн байна.
3.5 Иргэн, байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4.12, 10 дугаар зүйлийн 2.10 дах заалтуудын дагуу дүүрэг, хорооноос тогтоосон, "хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар"-ын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг тээвэрлүүлнэ.
3.6 Захиалагч тал нь гэрээний 3.2, 3.3-т заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа иргэн, байгууллагад учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
3.7 Хог хаягдлын хураамжийг сар бүрийн 15-аас 20-ны дотор Баянгол дүүргийн Татварын Хэлтэс болон itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэх цэсийг ашиглан үүссэн төлбөрийн даалгаварын дугаараар төлнө. Татварын лавлах 1800-1288, Баянгол дүүргийн Татварын хэлтсийн лавлах 70001288, 21254427
3.8 Хог ачилтын цэг, сав, бункерийн орц, гарцыг хааж автомашин болон бусад зүйл байрлуулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
3.9 Захиалга буюу хог хаягдал ачих, тээвэрлэх дуудлагыг 2-3 хоногийн өмнө хороо болон гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
3.10 Хог хаягдлын хураамжийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
3.11 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх;
3.12 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;
3.13 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах;
3.14 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд үүргээ биелүүлэхийг шаардах;
3.15 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.

**Дөрөв. Хорооны Засаг даргын эрх, үүрэг**

4.1 Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах, эдгээр үйл ажиллагаар эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, дэмжиж ажиллах;
4.2 Иргэн, байгууллагад хог хаягдлын талаарх байгальд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг зүй зохистой хаях, ангилах, дахин ашиглах дадал зуршлыг төлөвшүүлэх, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдлэгтэй болоход чиглэсэн ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
4.3 Хог хаягдалтай холбоотой хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тооцох, тооцуулах санал гаргах;

4.4 Хог хаягдлын цогц менежментийг бий болгон боломжит арга, технологи, байгальд ээлтэй практик нэвтрүүлэх, хог хаягдлын тухай боловсролыг иргэдэд олгох замаар зөв дадал, ухамсрыг төлөвшүүлэх;

4.5 Хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаар сайжруулах санал санаачлага гаргах, хорооны нутаг дэвсгэрт үүсмэл цэг үүсэхээс сэргийлэх, тээвэрлэлтийн хуваарьтай өдөр хогоо ачуулж хэвшүүлэх ажлыг гэр хороолол бүхий хороодод зохион байгуулж, хяналт тавих;

4.6 Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтуудын дагуу дүүрэг, хорооноос тогтоосон “хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар”-ын хог хаягдал, цас мөсийг арилган, талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг тээвэрлүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах;

4.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

**Тав. Төлбөр тооцоо, үнэлгээ**

5.1 Гэрээт хугацаанд сард ..1.. удаа иргэн, байгууллагын ахуйн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

5.2 Хог хаягдлын хураамж нь Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолд баталсан тарифын дагуу сард 100.000 төгрөг, улиралд 300.000 төгрөг, жилд 1.200.000 төгрөг байна.

5.3 Захиалагч нь itax.mta.mn цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэн нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө. Хог хаягдлын хураамж төлөх гэрээний 3.6-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алдангийг Захиалагч төлнө.

5.4 Захиалагч нь татварын itax.mta.mn цахим хаягаар хог хаягдлын хураамж төлөх төлбөрийн даалгавар үүсгэхдээ *“Сум, хороо”* сонгох хэсэгт: *Дүүргийн төвлөрсөн төсөв*, Төлбөр *“хүлээн авагч байгууллага”* сонгох хэсэгт: *Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ*-ыг тус тус сонгоно.

5.5 “Хог хаягдлын тухай” хууль, бусад эрх зүйн актыг үндэслэн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үйлчилгээний үнийн тарифт холбогдох эрх бүхий байгууллагаас өөрчлөлт оруулж болно.

5.6 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд хог хаягдлын хураамжийг Захиалагч төлсний дараа Гүйцэтгэгч хог тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

5.7 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу хог хаягдлын хураамж төлөгдсөний дараа тээвэрлэнэ.

5.8 Нийслэл, дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь өөрчлөгдөх тохиолдолд тухайн иргэн, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

**Зургаа. Бусад**

6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, авто зам хаагдах зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хог ачих боломжгүй болсон тохиолдолд Гүйцэтгэгч хариуцлага хүлээхгүй болно.

6.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.3 Тус гэрээнд дүүрэг, хорооноос тогтоосон *“Хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар”*-ын зураглалыг кадастр болон фото зураг хавсаргана.

6.4 Талууд аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.5 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

6.6 Гэрээг 3 эх хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

**Долоо. Нэмэлт нөхцөл**

7.1 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолын хавсралтын хэрэгжилтийг хангах

7.2 ……………………………………………………………………………………
……………………………………………………………………………………
……………………………………………………………………………………
……………………………………………………………………………………
……………………………………………………………………………………
……………………………………………………………………………………

**Найм. Нэмэлт өөрчлөлт**

8.1 20 ... оны ... сарын ... ны өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах өөрчлөлтийг оруулав.

……………………………………………………………………………………
……………………………………………………………………………………
……………………………………………………………………………………

**Ес. Гэрээний хавсралт**

9.1 Хог хаягдлын хураамж төлөлтийн тодотгол 2 хуудас

**Арав. Гэрээний сунгалт**

10.1 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

10.2 Энэхүү гэрээг 20... оны ... сарын ... өдрөөс 20.. оны ... сарын ... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

**Гэрээ байгуулсан:**

| | | |
|---|---|---|
| 20-Р ХОРООНЫ АЖЛЫН АЛБА<br>…………………… /<br>/ …………………… /<br>Утас: 80800290<br>Хаяг: ……………………<br>…………………… | ГҮЙЦЭТГЭГЧ:<br>БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ ОНӨААТҮГ-ЫН ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН<br>Б.Жавзанжулам<br>/ …………………… /<br>Утас: 80059002<br>Хаяг: 808<br>20р хороо<br>Баянгол 17405<br>Баянгол дүүргийн Татварын хэлтсийн мэргэжилтэн<br>Утас: …………………… | ЗАХИАЛАГЧ:<br>Албан тушаалтан<br>/ …………………… /<br>Утас: ……………………<br>Хаяг: ……………………<br>…………………… |

Зураг 19. Шингэн хог хаягдлын гэрээ

БАТЛАВ:
"ТУНАМАЛ ХИЙЦ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
............/Б.МАШБАЯР/

БАТЛАВ:
"МАРГАД ЭРДЭНЭ УУЛ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
............/Ё.МАНДАХ/

**ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН ШИНГЭН ХОГ ХАЯГДАЛ ЗӨӨВӨРЛӨХ, ШУГАМЫН БӨГЛӨРӨЛ ГАРГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар: AR / 24 / 33

2024 он 04 сар 15өдөр Улаанбаатар хот

Нэг талаас **"ТУНАМАЛ ХИЙЦ" ХХК"** (цаашид "Захиалагч" гэх) /РД: 5115523, түүнийг төлөөлж ерөнхий менежер албан тушаалтай Ц. Нарантуяа , нөгөө талаас **"МАРГАД ЭРДЭНЭ УУЛ" ХХК** (цаашид "Гүйцэтгэгч" гэх) /РД: 6342612/, түүнийг төлөөлж менежер Ж.Марал нар доорх нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. НИЙТЛЭГ ЗААЛТ**

1.1. Гүйцэтгэгч тал захиалагчийн хүсэлтээр бохир ус тээвэрлэх үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.

1.2. Дээрх ажил нь байгаль хамгаалах хууль, ариун цэврийн тухай хууль, бусад холбогдох дүрэм зааварт бүрэн нийцсэн байна.

1.3. Хоёр тал харилцан тохиролцсоноор үйлчилгээний ажлын гүйцэтгэл доорх үнэтэй байна. Уг дүнд НӨАТ болон Бохир ус цэвэршүүлсэний төлбөр багтсан болно. Үүнд:

**10тн - 220,000₮** / Хоёр зуун хорин мянган төгрөг/
**Буудлага – 280,000₮** /Хоёр зуун наян мянган төгрөг/
/Буудлага - Худаг хоорондын бөглөрлийг усаар буудаж гаргах, бохирын лагийг өндөр даралттай усаар хөдөлгөж соруулах/

1.4. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд энэхүү гэрээ нь 2024 оны 04-р сарын 15-ны өдрөөс 2025 оны 04-р сарын 15-ны өдөр хүртэл хүчинтэй байна.

1.5. Гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон ч аль нэг тал цуцлах тухай бичгээр мэдэгдээгүй тохиолдолд гэрээг 1 жилээр сунгасанд тооцно.

**Хоёр. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. Үйлчилгээний дуудлагыг тухайн бохир ус тээвэрлэлт хийлгэх өдрийн өмнөх өдөр гүйцэтгэгчид өгсөн байна. /Дуудлагын утас: 9626-7373/

2.2. Бохир ус сорох явцад хяналт тавьж, дутуу сорсон тохиолдолд тухай бүрт нь гүйцэтгэгчид мэдэгдэж, шаардлага тавьж, доголдлыг тогтоон өөрийнх нь зардлаар дахин соруулна.

2.3. Гүйцэтгэгч тал Приус центрийн дурын салбараас ижил үнээр хэрэглээнээс гарах шингэн хаягдал усаа соруулах эрхийг эдэлнэ.

2.4. Зайлшгүй шаардлагатай нэмэлт ажил /шугамын бөглөрөл гаргах, лайдах, худаг цэвэрлэгээ гэх мэт/ гарвал үйлчилгээг гүйцэтгэгчтэй харилцан тохиролцсоны дагуу үйлчилгээг хийлгэнэ.

2.5. Төлбөрийг дансаар тохиролцсоны дагуу төлнө.

2.6. Ажлын хөлсийг дараа сарын хуанлийн эхний 5 /тав/ өдөрт нэхэмжлэх бөгөөд нэхэмжилсэнээс хойш захиалагч тал хуанлийн 5 /тав/ өдөрт багтаан гүйцэтгэгчид төлнө. Нэхэмжилсэн дүнг "МАРГАД ЭРДЭНЭ УУЛ" ХХК-ийн 5009952783 /Хаан Банк/ тоот дансанд шилжүүлнэ.

## Гурав. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн өгсөн дуудлагын дагуу бохир ус тээврийн ажил гүйцэтгэлийг 8-10 цагийн дотор шуурхай хийж гүйцэтгэнэ.

3.2. Захиалагчийн соруулуулах бохирын цооногийг судалж үнийн дүнг тогтоох, өөрчлөх талаар санал тавьж тохиролцоно.

3.3. Гүйцэтгэгч тал ажил гүйцэтгэхээр очсон үед дуудлага өгсөн захиалагч талаас биеэр хяналт тавина.

3.4. Хяналт тавиагүйгээс гарах асуудлыг гүйцэтгэгч тал хариуцахгүй.

3.5. Үйлчилгээ гүйцэтгэх явцад захиалагч талаас шалтгаалж /бохирын хоолойн бүрэн бус байдал, ус алдалт, цооног, хөлдөлт гэх мэт/ доголдол гарвал гүйцэтгэгч тал дахин үйлчилгээ хийж, ажлын хөлсийг нэмж тооцон нэхэмжилнэ.

3.6. Гүйцэтгэгч тал нь захиалагч талын орчин тойрон болон эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.7. Гэрээний хугацаа дуусах хугацаанаас өмнө урьдчилан мэдэгдэлгүй гэрээг цуцалж өөр байгууллага, хувь хүмүүсээр үйлчилгээ хийлгэсэн тохиолдолд гэрээ дуусах хугацаа хүртэл гүйцэтгэгч ажил үүргээ гүйцэтгэсэнд тооцон тухайн хугацаанд гүйцэтгэх байсан ажлын өртгийг үл маргах журмаар нөхөн авах эрхтэй.

## Дөрөв. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Захиалагч болон гүйцэтгэгч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үнийн дүнгийн 0,5% -тай тэнцэхүйц торгууль хүлээнэ.

4.2. Захиалагч гэрээнд заасан үүргээ өөрийн буруугаас биелүүлээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол гүйцэтгэгчид учирсан зардал, хохирлыг хариуцана.

4.3. Талууд гэрээний хугацаа дуусахад хийж гүйцэтгэсэн ажлыг харилцан ярилцаж, "Гэрээ дүгнэх хуудас" -г бөглөж, гэрээг шинэчилэн байгуулна.

4.4. Хэрэв талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.

4.5. Гүйцэтгэгч талын буруутай үйлдлээс болж захиалагч талын эд хөрөнгө эвдэрч гэмтсэн тохиолдолд гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж зах зээлийн үнээр төлж барагдуулна.
/Үүнд: хашаа хайс, бордюр, зүлэг ногоо гэх мэт/

4.6. Бохирын цооног хоггой байснаас гүйцэтгэгч талын машин техникт гэмтэл гарвал гүйцэтгэгч талын хохирлыг захиалагч тал бүрэн хариуцаж барагдуулна.

4.7. Гүйцэтгэгч тал бохир тээвэрлэхээр очих үед машины ёмкость ямагт хоосон байна.

## Тав. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, цаг агаарын саатал, зам боогдох, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт гэх мэт/, нөхцөл байдлыг арилгах хүртэл ажил гүйцэтгэх хугацааг хойшлуулж болно.

5.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

## Зургаа. НЭМЭЛТ НӨХЦӨЛ

6.1. Захиалагч бохирын цооногийн бүрэн бүтэн байдлыг хангаж хогтүй цэвэр байлган машины орц, гарцыг чөлөөтэй байлгана.

6.2. Бохирын цооногтой холбоотой нэмэлт үйлчилгээ /худаг цэвэрлэгээ, лайдах, бөглөрөл гаргах, буудлага хийх гэх мэт/ хийх шаардлагатай үед талууд төлбөрийг харицан тохиролцож, гүйцэтгэгч тал чанартай түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.

6.3. Бензин шатахууны үнэ нэмэгдэхэд тээврийн хөлсийг дахин ярилцан тохиролцож тодорхой хувиар нэмнэ.

## Долоо. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

7.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

**"ТУНАМАЛ ХИЙЦ" ХХК**

Хаяг: Улаанбаатар хот, БГДүүрэг,
3-р хороо, ТЭЦ 4 баруун хойно
Утас: 9199-3012
И-Мэйл: tunamal_hiits@yahoo.com

Ерөнхий менежер:
……………… /Ц. Нарантуяа/
Утас: 9199-3013
И-Мэйл: tunamal_hiits@yahoo.com

Нягтлан бодогч:
………………… / Н. Байгалмаа/
Утас: 9199-3012
И-Мэйл: tunamal_hiits@gmail.com

**"МАРГАД ЭРДЭНЭ УУЛ" ХХК**

Хаяг: Улаанбаатар хот, БГДүүрэг,
3-р хороо, Энгельсийн гудамж, 3-176
Утас: 9626-7373, 8801-4140
И-Мэйл: margaderdeneuul@gmail.com

Менежер:
……………… / Ж.Марал /
Утас: 9626-7373
И-Мэйл: margaderdeneuul@gmail.com

Нягтлан бодогч:
……………… / Б.Эрхэмжаргал /
Утас: 9912-1354
И-Мэйл: margaderdeneuul.office@gmail.com

Зураг 20. Эмнэлгийн үзлэгийн гэрээ

БАТЛАВ.
“ГУРВАН ГАЛ” НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
................ Г.ПҮРЭВСҮРЭН.

БАТЛАВ.
“ТУНАМАЛ ХИЙЦ” ХХК-НЫ
ЗАХИРАЛ
................ Б.МАШБАЯР

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ, ЗӨВЛӨГӨӨНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ**

2025 оны 06 сарын 12 өдөр №2025-...... Улаанбаатар хот

Энэхүү эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээ хийх гэрээг нэг талаас улсын бүртгэлийн дугаарт бүртгэгдсэн, **2600536** тоот регистрийн дугаартай “Гурван гал” нэгдсэн эмнэлэг (цаашид “Эмнэлэг” гэх), түүнийг төлөөлж Эмнэл зүй эрхэлсэн захирал Лувсанбазар овогтой Баярцэцэг, Салбар клиник эрхэлсэн дэд захирал албан тушаалтай Хоролсүрэн овогтой Мөнгөнсувд, нөгөө талаас улсын бүртгэлийн 9011084096 тоот регистрийн дугаартай "Тунамал Хийц" ХХК (цаашид “Үйлчлүүлэгч байгууллага” гэх), түүнийг төлөөлж Ерөнхий менежер Цэцэгмаа овогтой Нарантуяа (цаашид хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 189.5-р зүйлийг удирдлага болгон доор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Эмнэлэг нь үйлчлүүлэгч байгууллагын хүсэлтээр харилцан зөвлөлдөж урьдчилан сэргийлэх үзлэгийн багцыг сонгов.

1.2. Төлбөртэй тусламж үйлчилгээнд сонгосон багцаар үйлчилнэ.

1.3. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах ажилтны тоон мэдээлэл 19 байна.

1.4. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

1.5. Энэхүү гэрээг талууд 2025 оны 06 дугаар сарын ~~17~~ 18,19-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Энэ өдрүүдэд 08:30 цагуудад хамрагдана. Гурван гал эмнэлгийн удирдлага болон олон нийт үйлчлүүлэгчтэй харилцах алба, бусад мэргэжлийн эмч нар, лабораторийн шинжилгээтэй гүйцэтгэхээр ажиллах болно.

1.6. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

**ХОЁР. ЭМНЭЛГИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

2.1 Үйлчилгээ авч буй харилцагч байгууллагад ээлтэй үйлчилгээ үзүүлэх, эмч нарын цаг зохицуулалтуудыг зохион байгуулалттай хийж өгөх үүрэгтэй.

2.2 Эмнэлэг нь үйлчлүүлэгч байгууллагын ажилтан тус бүрийн эрүүл мэндтэй нь холбоотой нууцыг чанд хадгалж, бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

2.3 Эмнэлэг нь өөрийн эмч, ажилчдын ёс зүйн асуудалд онцгойлон анхаарч, үйл ажиллагааны дотоод журам, ажилтнуудынхаа ажил үүргийн хуваарийг нарийвчлан гаргаж мөрдүүлсэн байна.

2.4 Эмнэлэг нь үйлчлүүлэгч байгууллагаас ажилчдын мэдээллийг хуваарийн дагуу бүрэн ирүүлэхийг шаардах эрхтэй.

2.5 Эмнэлэг нь үйлчлүүлэгч байгууллагаас үзлэг зөвлөгөөнд тавигдах шаардлагыг биелүүлэх, урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж өөрийн ажилтнуудад холбогдох мэдээлэл, зааварчилгаар өгсөн байхыг шаардах эрхтэй.

2.6 Эрүүл мэндийн байгууллага нь харилцагч байгууллагын ажилтанд ээлтэй урьдчилан сэргийлэх үзлэг хийх багаж хэрэгслийн ариутгал халдваргүйтгэлийг хийсэн байх үүрэгтэй Тухайн байгууллагын үзлэг, зөвлөгөөнд орсон ажилтнуудад эмч үзлэг хийгээд дүгнэлт хийж, зөвлөгөө зөвлөмж бичих үүрэгтэй.

## ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гэрээнд заасан хугацаанд Гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу саадгүй хугацаанд нь ажилтнууд хамруулах үүрэгтэй.

3.2. Ажилчдын ургийн овог, овог, нэр, хүйс, регистрийн дугаар, гэрийн хаяг, утасны дугаар, үзлэг, зөвлөгөөнд хамрагдах хуваарийг гаргаж үзлэг эхлэхээс ажлын 2 хоногийн өмнө эмнэлэгт ирүүлсэн байна.

3.3. Үйлчлүүлэгч байгууллагаас үзлэг, зөвлөгөөнд хамрагдах үед тавигдах шаардлагыг биелүүлэх, ажилтнуудад тухайн байгууллагын эмч, нийгмийн ажилтан холбогдох мэдээлэл, зааварчилгаа, мэдээллийг танилцуулж зөвшөөрөл авсан байна.

3.4. Үйлчлүүлэгч байгууллагын ажилтан албан хаагчид урьдчилсан нөхцлийг хангаагүй хүндрэл учирсан тохиолдолд эмнэлэг хариуцахгүй болно.

## ДӨРӨВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

4.1 Төлбөрийг урьдчилан сэргийлэх багц орохоос 2 хоногийн өмнө нийт үнийн дүнг шилжүүлсэн байна.

4.2 Төлбөртэй үзлэгийн нэг үйлчлүүлэгчийн багц 356,900 ( гурван зуун тавин зурган мянга есөн зуун төгрөг) , 371,400 ( гурван зуун далан нэгэн мянга дөрвөн зуун төгрөг)
Төлбөрийг Голомт банкны **1805215852 / IBAN 55001500** дансанд байршуулна.
Бусад эмчилгээ үйлчилгээ сонгосон багцын дагуу төлбөртэй явагдана.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1. Гэрээний дагуу эмчийн үзлэг,зөвлөгөөнд заасан хугацаанд ажилтан албан хаагчдыг хариуцлагатайгаар оролцуулна.

5.2. Гэрээний гүйцэтгэл хариуцан ажиллаж буй мэргэжилтэн зохион байгуулагч хамтран ажиллана.

## ЗУРГАА. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ЦУЦЛАХ

6.1. Энэхүү гэрээнд заасан хугацаагаа ажлын өдрөөр бодох бөгөөд талуудыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.

6.2. Энэхүү гэрээний хугацаа дуусгавар болох мөн гэрээ цуцлагдсанаар талуудад энэхүү гэрээгээр олгогдсон эрх, үүрэг мөн дуусгавар болно.

## ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

7.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд юуны түрүүнд эвийн журмаар зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

7.2. Хэрэв талууд ажлын 10 (арав) хоногийн дотор гарсан маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.3. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн бусдад шилжүүлэхгүй.

7.4. Талууд энэхүү гэрээтэй холбогдуулан бие биедээ хийх мэдэгдлийг бичгээр, факсаар эсвэл и-мэйлээр гэрээнд заасан хаяг руу илгээнэ.

7.5. Гэрээний хугацаанд аль ч тал нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болох бөгөөд саналыг хүлээн авсан тал ажлын 3-аас доошгүй хоногийн дотор нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаарх өөрийн саналыг хариу мэдэгдэнэ. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тэмдэглэлийг бичгээр үйлдэж, гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

## Тунамал Хийц ХХК-ны ТӨЛБӨРТЭЙ ОРОХ БАГЦЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц-02 | | Үндсэн үнэ | Хөнгөлөлттэй үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Дотрын эмчийн үзлэг | | 60,000.00 | 60,000.00 |
| | Цусны дэлгэрэнгүй шинжилгээ | | | |
| 2 | Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (CBC) | CBC+diff | 33,400.00 | 32,900.00 |
| | Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ | | | |
| 3 | Шээсний ерөнхий шинжилгээ | - | 13,000.00 | 28,500.00 |
| 4 | Шээсний тунадасны шинжилгээ | - | 16,500.00 | |
| 5 | Хэвлийн эхо | | 50,000.00 | 50,000.00 |
| 6 | Зүрхний бичлэг | | 25,000.00 | 12,500.00 |
| 7 | Рентгэн харах | | 25,000.00 | 12,500.00 |
| 8 | ходоодны дуран | | 100,000.00 | 100,000.00 |
| 9 | бүдүүн гэдэсний ~~цус алдалт~~ далд цус шүүрүүх | | 75,000.00 | 75,000.00 |
| | Хөнгөлөлт | | 0 | 371,400.00 |

| № | Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц-02 | | Үндсэн үнэ | Хөнгөлөлттэй үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Дотрын эмчийн үзлэг | | 60,000.00 | 60,000.00 |
| | Цусны дэлгэрэнгүй шинжилгээ | | | |
| 2 | Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (CBC) | CBC+diff | 33,400.00 | 32,900.00 |
| | Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ | | | |
| 3 | Шээсний ерөнхий шинжилгээ | - | 13,000.00 | 28,500.00 |
| 4 | Шээсний тунадасны шинжилгээ | - | 16,500.00 | |
| 5 | Хэвлийн эхо | | 50,000.00 | 50,000.00 |
| 6 | Зүрхний бичлэг | | 25,000.00 | 12,500.00 |
| 7 | Рентгэн харах | | 25,000.00 | 12,500.00 |
| 8 | Бамбайн шинжилгээ | | 85,500.00 | 85,500.00 |
| 9 | бүдүүн гэдэсний цус ~~алдалт~~ илрүүлэх шинжилгээ | | | 75,000.00 |
| | Хөнгөлөлт | | 0 | 356,900.00 |

### ТАЛУУДЫН ГАРЫН ҮСЭГ:

**Эмнэлгийг төлөөлж:**

Х.Мөнгөнсувд
.........(гарын үсэг).........

Салбар клиникүүд эрхэлсэн дэд захирал

**Үйлчлүүлэгч байгууллагыг төлөөлж:**

Ц.Нарантуяа
.....(гарын үсэг).............

Ерөнхий менежер

Хаяг:
"Гурван гал" нэгдсэн эмнэлэг,
Монгол улс, Улаанбаатар хот,
БГД-ийн 11-р хороо эх нялхасын 19 тоот
Утас: +976- 70113344, 99993894
Цахим хаяг: mungunsuvd@ggh.mn

Хаяг:
" Тунамал Хийц "ХХК,
Монгол улс,
Улаанбаатар
хот
БГД-ийн 20-р хороо
үйлдвэрлэлийн бүс 3
Утас: 91993013,
91993012
Цахим хаяг:
tunamalkhiits@gmail.com

Зураг 21. Бетон зуурмаг тээвэрлэх тээврийн хэрэгсэлтэй хувь хүнтэй хамтран ажиллах гэрээ

Батлав: "Тунамал Хийц" ХХК-ний
Захирал: Б.Машбаяр

### Хамтран ажиллах гэрээ

2025 оны 03 -р сарын 01-ны өдөр № 025/001 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "Тунамал Хийц" ХХК-ийг төлөөлж Захирал Б.Машбаяр /цаашид Ажил олгогч гэх/, нөгөө талаас төлөөлж хамтран ажиллах жолооч нар цаашид Гүйцэтгэгч гэх / нар Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

**Нэг: Гэрээний зорилго буюу гүйцэтгэх, гүйцэтгүүлэх ажил**

1.1 Ажил гүйцэтгэгч нь өөрийн тээврийн хэрэгслээр ажил олгогчийн үйлдвэрлэсэн бетон зуурмагийг гэрээт газруудад саадгүй тээвэрлэн үйлчлэх зорилготой.

**Хоёр. Ажлын гүйцэтгэх үндсэн хугацаа**

2.1 Энэхүү гэрээний үндсэн хугацаа нь 1 жил хүртэлх хугацаа болно.

2.2 Гэрээний хугацаа дуусгавар болсон үед гэрээг дүгнэж цаашид сунгах тал дээр борлуулалт, үйлдвэр, санхүүгийн хэлтэсүүдээс санал асуулга авч талуудаас ямар нэгэн санал гараагүй тохиолдолд дахин сунгагдана.

**Гурав: Ажлын хөлс ба төлбөр**

3.1 Тээврийн хөлс 1 м$^3$-ыг 1м$^3$- 25,000 / Э-Баримт орсон / төгрөг байна.

3.2 Тооцоог сард 1 удаа талбайн инженерийн гарын үсэг бүхий баримтыг үндэслэн тооцоо нийлж тооцоо нийлсэн акт үйлдэнэ.

3.3 Тээврийн хөлсийг бартерийн журмаар өгөх ба сэлбэг болон түлшийг компаниас шийдэж тээврийн хөлснөөс хасч тооцно.

**Дөрөв: Ажил олгогчийн эрх, үүрэг**

4.1 Ажил олгогч тал нь ажлын графикийг өмнөх өдөрт харилцагч ба талбайн нэр, эхлэх цагийн хамт гүйцэтгэгч талд мэдээллэх

4.2 Ажил олгогч нь миксер машины үйлдвэрт орж ирсэн дэс дараалаар бетон зуурмагийг үйлдвэрлэж өгөх

4.3 Гүйцэтгэгч талд үйлдвэр дотор ажиллах журмыг зааварчилан мөн жолооч нарт шаардлага тавих эрхтэй.

4.4 Ажил олгогч тал цаг хугацаанд нь төлбөр тооцоог хийж байх

4.5 Зуурмагийн баримтын 1 хувийг авч ирээгүй тохиолдолд төлбөр гүйцэтгэхгүй байх эрхтэй.

4.6 Шаардлагатай үед холбогдох утас: 9199-3013

**Тав: Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

5.1 Гүйцэтгэгч тал нь өглөө 09:00 -д ажилд ирэх ба ажил олгогч талын захиалагт ажлыг хол ойр ялгалгүй цаг алдалгүй тээвэрлэх бөгөөд тухайн өдөр дугаарын хязгаарлалттай болон хүндэтгэх шалтгаантай / машины эвдрэл болон ар гэрийн гачигдал/ миксерээс бусад бүх гэрээт миксерүүд тухайн өдрийн ажлын сүүлийн захиалгыг өгөх дэс дараалалын дагуу хүлээж ажлыг дуусгавар болгоно. Тухайн өдөр ажил олгогчид захиалгат ажил байхгүй бол нийт үйлдвэрт гэрээ байгуулан хамтран ажиллаж байгаа тээврийн 50% хүртлэх хувь нь үлдэж үйлдвэр тартал байна.

5.2 Барилга угсралтын ажлыг саатуулахгүйгээр тээврийн ажлыг гүйцэтгэхэд өөрийн машин техникийг бүрэн бүтэн сааталгүй ажиллуулах ба тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг бүрэн хариуцаж ажиллах

5.3 Бетон зуурмаг үйлдвэрлэгдэж тээвэрлэгдэн гарснаас хойш жолоочийн буруутай үйлдэл машины эвдрэлээс /дугуй хагарах, шатахуунгүй зогсох мөн бусад гэмтэл/ болон талбайд буулгаж чадалгүй **2.00** цаг өнгөрвөл үйлдвэрлэлийн шаардлага хангахгүй болсоноос үүссэн хохирлыг бетон зуурмагийг тээврийн гүйцэтгэгч тал хариуцан төлнө.

5.4 Тохирох ангилалгүй жолоочоор тээврийн хэрэгсэл бариулах, хөдөлгөөнд оролцуулахыг хатуу хориглоно. Жолооч нартаа хөдөлмөрийн сахилга бат, дэг журам сахих, анхаарал болгоомжтой ажиллах мөн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаар байнга өгч байх ба уг журамыг мөрдөөгүйгээс ямарваа нэгэн осол үүссэн тохиолдолд ажил олгогч тал хариуцахгүй.

5.5 Гүйцэтгэгч нь захиалгыг гүйцэтгэж гарахаа мэдэгдсэнээр гэрээ хэрэгжих ба компанийн графикт ажлыг тасалдуулж өөр компаний ажилд ажил олгогч талтай урьдчилан тохиролцоогүйгээр явахгүй байх үүрэгтэй. Хэрэв ийм тохиолдолд ажил олгогч тал гэрээг автоматаар цуцлах боломжтой.

5.6 Гүйцэтгэгч нь тээврийн хэрэгслээрээ үүрэг гүйцэтгэж байх үедээ өөрийн холбоо барих хэрэгсэл утсаа заавал асаалттай байлгах үүрэгтэй.

5.7 Тухайн тээврийн хэрэгсэл дээр ажил олгогч талын логог наана.

5.8 Гүйцэтгэгч нь байнга торхны цэвэрлэгээг цаг тухайд нь хийнэ. Торхоо цэвэрлэзгүйгээс шалтгаалан замаар асгасан хариуцлага, төлбөрөө жолооч өөрөө хариуцна.

5.9 Гүйцэтгэгч нь торхны цэвэрлэгээ болон автомашины засварыг хийхдээ тогтоосон газарт хийх бөгөөд ойр орчмыг бохирдуулах асуудлыг гаргахгүй байх үүрэгтэй ба гаргасан тохиолдолд өөрөө цэвэрлэнэ.

5.10 Гүйцэтгэгч нь харилцагч байгууллагууд тэдгээрийн инженер ажилчидтай барилгын талбай дээр зөв боловсон харьцах машины өнгө үзэмжин дээр анхаарч ажилана.

5.11 Гүйцэтгэгч нь ажил олгогчын үйлдвэрийн бүсэд гэрээ хийсэн ажилд гарах автомашинаас бусад хувийн өмчийн тээврийн хэрэгсэлийг оруулахыг хориглоно. Жич: Суудлын автомашиныг зориулалтын зогсоолд байрлуулна.

5.12 Гүйцэтгэгч нь ажлын байранд архи согтуурах ундаа хэрэглэх, хэрэглэсэн үедээ ирэхийг хатуу хорилоно. Удаа дараа зөрчсөн тохиолдолд гэрээг дуусгавар болгоно.

5.13 Тээвэр хийх машины дугаар : Хавсралтаар

**Зургаа. Бусад нөхцөл**

6.1 Энэхүү гэрээ нь харилцан гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болж, гэрээний хугацаа дуустал хүчин төгөлдөр байна.

6.2 Гэрээг хоёр хувь үйлдсэн бөгөөд хувь тус бүр нь адил хүчин төгөлдөр байна.

6.3 Хоёр тал аливаа маргаантай асуудлыг харилцан хэлэлцэж, зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд асуудлыг Монгол улсын холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

Тунамал хийц

УЛААНБААТАР ХОТ
ТУНАМАЛ ХИЙЦ ХХК

Хавсралт 1

| № | Машины дугаар | Жолоочын нэр | Хэмжээ | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | 46-97УБВ | Пүрэвсүрэн | 7м3 | |
| 2 | 04-76УБВ | Уранцэцэг | 9м3 | |
| 3 | 73-57УЕК | Цогмандах | 12м3 | |
| 4 | 35-67УБИ | Ганцоож | 7м3 | |
| 5 | 79-74УБТ | Амаржаргал | 6м3 | |
| 6 | 14-46УБО | Мягмарсүрэн | 12м3 | |
| 7 | 84-91УНӨ | Эрдэнэбаатар | 6м3 | |
| 8 | 88-60УАТ | Баянмөнх | 8м3 | |
| 9 | 39-22УНМ | Батбаатар | 12м3 | |
| 10 | 93-20УБП | Балжинням | 10м3 | |
| 11 | 81-34УБС | Мөнх-Эрдэнэ | 7м3 | |
| 12 | 26-19УБР | Нарантуяа | 9м3 | |
| 13 | 56-67УНЧ | Г. Даваадорж | 12м3 | |
| 14 | 72-67УНХ | Г. Даваадорж | 10м3 | |
| 15 | 10-25УАТ | Гантөмөр | 9м3 | |
| 16 | 65-48УНЕ | Мөнхтулга | 12м3 | |
| 17 | 11-96УАТ | Н. Даваадорж | 9м3 | |
| 18 | 07-08УАО | Эрдэнэбаатар | 12м3 | |
| 19 | 25-88УАТ | Батбаяр | 8м3 | |
| 20 | 18-62УЕМ | Цогтдэлгэр | 44м | |
| 21 | 18-62УБЧ | Цогтдэлгэр | 9м3 | |
| 22 | 20-26УЕН | Ундрахбаатар | 8м3 | |
| 23 | 44-05УКА | Бямбатогтох | 12м3 | |
| 24 | 30-38УБВ | Баасанжаргал | 20тн | |
| 25 | 77-54УЕХ | Амаржаргал | 12м3 | |
| 26 | 40-90УКУ | Батбаяр | 25тн | |
| 27 | 30-46УНИ | Батсайхан | 7м3 | |
| 28 | 94-71УАК | Энхтүвшин | 9м3 | |
| 29 | 72-29УКМ | Дашдорж | 12м3 | |
| 30 | 69-07УНЗ | Нарангэрэл | 9м3 | |
| 31 | 7452УКМ | Наранжаргал | 10м3 | |
| 32 | 84-72УАР | Даваа | 20тн | |
| 33 | | | | |
| 34 | | | | |
| 35 | | | | |
| 36 | | | | |
| 37 | | | | |
| 38 | | | | |
| 39 | | | | |
| 40 | | | | |

Зураг 22. Галын дүгнэлт



Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 75 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

# ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0027861

Иргэн, хуулийн этгээдийн нэр: "Тунамал хийц" ХХК

Хаяг: БГД 20р хороо 735-р байрны хойно

Эрхлэх үйл ажиллагааны чиглэл: Бетон зуурмагийн үйлдвэр

Барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхэд энэ дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2, 23 дугаар зүйлийн 23.3/
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Хяналт шалгалт хийсэн 2025 он 04 сар 10 өдөр
Олгосон: 2025 он 04 сар 18 өдөр
Хүчинтэй хугацаа: 2026 он 04 сар 18 өдөр хүртэл

Баталгаажуулсан:
БГД аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга ........ цолтой ........ Н.О.

Дүгнэлт олгосон:
БГД аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч: ахлах цолтой ........

/тэмдэг дарна/

Зураг 23. Хөрсний шинжилгээний дүн

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

MNAS

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

**Дугаар: 25/476**

**Дээж авсан огноо:** 2025 он 04 сарын 17
**Шинжилгээ хийсэн огноо:** 2025 он 04 сарын 21-22
**Дээж авсан газрын нэр:** Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ТЭЦ-4 баруун хойно
**Координат:** -
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Тунамал хийц"ХХК
**Харилцах утас:** 91993013

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг, % | $NO_3$ мг/100г | $CaCO_3$, % | Шингээгдсэн суурьууд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 25/2388 | Хөрс-1 | - | 8.81 | 0.07 | 0.153 | 0.86 | 0.31 | 0.16 | 10.1 | 6.2 | 2.3 | 7 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 25/2388 | Хөрс-1 | - | 41.4 | 32.3 | 9.0 | 5.0 | 8.5 | 3.8 | 17.3 |

***Хөрсний хүнд металл***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 25/2388 | Хөрс-1 | - | 12.97 | ND | ND | 2.66 | 40.68 | 1.62 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

***Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.***

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Л. Цагаандархи /MS.c/
Задлан шинжээч: О.Дагвийжалам /MS.c/

Зураг 24. Усны шинжилгээний дүн

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

**Усны химийн шинжилгээний тодорхойлолт**

Сорьц авсан: 2025 оны 04 сарын 17 өдөр
Шинжилгээ хийсэн: 2025 оны 04 сарын 18 өдөр
Сорьц авсан газрын нэр: Баянгол дүүрэг, 20-р хороо, ТЭЦ4 баруун хойно, "Эм Си Эйч Эс" ХХК-ийн байр
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Тунамал Хийц" ХХК

Солбицол X=47°53'47.7" Y= 106°47'42.3"
Гүн: м
Ундарга: л/с

Уст цэгийн төрөл ба дугаар: худаг

Тодорхойлсон нь:

| Анион | 1 $дм^3$ -д байгаа | | | Катион | 1 $дм^3$ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 47.9 | 1.35 | 23.1 | $Na^+ + K^+$ | 47.0 | 2.04 | 34.9 |
| $SO_4^{--}$ | 95.0 | 1.98 | 33.8 | $Ca^{++}$ | 61.1 | 3.05 | 52.1 |
| $NO_2^-$ | 0.01 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | 9.1 | 0.75 | 12.8 |
| $NO_3^-$ | 14.0 | 0.23 | 3.9 | $NH_4^+$ | 0.15 | 0.01 | 0.1 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $HCO_3^-$ | 140.3 | 2.30 | 39.3 | $Fe^{+++}$ | 0.05 | 0.00 | 0.0 |
| Дүн | 297.2 | 5.86 | 100.0 | Дүн | 117.5 | 5.86 | 100.0 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 344.5 мг/ $дм^3$

Анион катионуудын нийлбэр: 414.7 мг/ $дм^3$

Ерөнхий хатуулаг: 3.80 мг-экв/ $дм^3$
pH: 6.89
EC:579 µS/cm
Исэлдэх чанар: 2.24 мг/ $дм^3$
TDS: 347 ppm

**Физик шинж чанар**

Тунгалаг: 30 см
Өнгө: үгүй
Тунадас: үгүй
Үнэр: ***
Амт: ***
Булингар: 2.66 NTU

Чөлөөт $CO_2$ 4.2 мг/$дм^3$
Карбонатын хатуулаг: 2.3 мг-экв/$дм^3$
Ерөнхий шүлтлэг 50.6 мг/$дм^3$
Идэмхий $CO_2$ 8.8 мг/$дм^3$

Усны найрлагын томъёо: $M_{0.43} \dfrac{HCO_3^- 39\ SO_4^{2-} 34\ Cl^- 23}{Ca^{2+} 52\ Na^+ + K^+ 35\ Mg^{2+} 13}$

**Дүгнэлт**

*Химийн бүрэлдэхүүнээрээ холимог ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Уг усны карбонатын хатуулаг 2.3 мг-экв/$дм^3$, ерөнхий шүлтлэг 50.6 мг/$дм^3$ байна. Гэвч манай улсад мөрдөгдөж байгаа "Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус" MNS ISO:12439-2012 стандартад карбонатын хатуулаг, идэмхий $CO_2$ болон бусад идэмхий үзүүлэлтүүдийн хэмжээг заагаагүй байна.*

*Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээг
Гүйцэтгэсэн: Химич, ЭШДэА ________ /Г. Энхжаргал/
Хянаж, баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч: ________ /Д. Гэрэлт-Од/

Зураг 25. Агаарын шинжилгээний дүн

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2025/А-244
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас :"Тунамал Хийц" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.05.02
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот БГД 20-р хороо үйлдвэр орчим
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6768:2019, САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2025.05.05
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м³ | | | ДБА |
| 1 | Үйлдвэрийн гадна талбай | 25/05/02 | 09:20 | 0.010 | 0.082 | 0.453 | 44 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч : Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

Зураг 26. 2025 оны БОМТ-ний зардлын 50%-ийг байршуулсан баримт



ХААН БАНК

Огноо/Date: 2025-07-31 16:23:40

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 32157510

Гүйлгээний дугаар /Poid: 1221472585

Системийн огноо/System Date: 2025-07-31 16:23:30

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5011063836 | Нэр/Name<br>ТУНАМАЛХИЙЦ | Дүн/Amount<br>2,882,750.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>MOFUMNUB<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>MN260090 000200555301 | Банкны нэр/Bank Name<br>ТӨРИЙН САН<br>Нэр/Name | 2,882,750.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-ТУНАМАЛ ХИЙЦ ХХК 5115523 БО ХАМГА

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



ХААН БАНК

Огноо/Date: 2025-08-12 14:16:46

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 20219710

Гүйлгээний дугаар /Poid: 1232283466

Системийн огноо/System Date: 2025-08-11 14:30:07

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>5011063836 | Нэр/Name<br>ТУНАМАЛХИЙЦ | Дүн/Amount<br>591,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>MOFUMNUB<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>MN260090 000200555301 | Банкны нэр/Bank Name<br>ТӨРИЙН САН<br>Нэр/Name | 591,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-ТУНАМАЛ ХИЙЦ ХХК 5115523 БО ХАГ

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Зураг 27. Ажилчдын амрах өрөө тохижуулсан зардлын баримт



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ПАДААН№:4235691063

ДДТД: 000002722542000250812000000929360
Борлуулагчийн:
ТТД: 2722542
НЭР: Эм Жи Эл Би
Хаяг: ........
Утас: ........
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......
Банкны IBAN дугаар: undefined

Огноо: 2025-08-12 02:53:20
Худалдан авагчийн:
ТТД: 5115523
Нэр: Тунамалхийц
Хаяг: ........
Утас: ........

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Барилгын угсармал төмөр хийц | 62 | ш | 1 | 0 | 11,000,000 |
| | | | | | Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 10,000,000 |
| | | | | | Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 1,000,000 |
| | | | | | Нийслэл хотын албан татвар: | 0 |
| | | | | | Нийт дүн: | 11,000,000 |

Хүлээн авсан: ........................................ /................................/
(гарын үсэг) (нэр)

Хүлээлгэн өгсөн: ........................................ /................................/
(гарын үсэг) (нэр)

Зураг 28. Гал унтраах багаж хэрэгсэл авсан зардлын баримт



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ПАДААН№:4241214122

ДДТД: 000002120712000251009000001701311
Борлуулагчийн:
ТТД: 2120712
НЭР: Гал-Импекс
Хаяг: ........
Утас: ........
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......
Банкны IBAN дугаар: undefined

Огноо: 2025-10-09 14:40:00
Худалдан авагчийн:
ТТД: 5115523
Нэр: Тунамалхийц
Хаяг: ........
Утас: ........

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | бараа | 62 | ш | 1 | 0 | 475,200 |
| | | | | | Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 432,000 |
| | | | | | Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 43,200 |
| | | | | | Нийслэл хотын албан татвар: | 0 |
| | | | | | Нийт дүн: | 475,200 |

Хүлээн авсан: ........................................ /................................/
(гарын үсэг) (нэр)

Хүлээлгэн өгсөн: ........................................ /................................/

Зураг 29. Хогийн сав, хог хаягдлын цэг байгуулсан зардлын баримт



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 000006614744000250430000001816485
Борлуулагчийн:
ТТД: 6614744
НЭР: Мөнхийн сарнай бадрах
Хаяг: Монгол, Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, 2-р 40 мянгат, 36 тоот
Утас:
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2025-04-30
Худалдан авагчийн:
ТТД: 5115523
Нэр: Тунамалхийц
Хаяг: Монгол, Улаанбаатар, Сонгинохайрхан, 15-р хороо, , 78
Утас: 91993012

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн металлаар хийсэн албан тасалгааны тавилгаас бусад бичиг хэргийн шүүгээ бичгийн хэрэгслийн тавиур эдгээртэй адил төстэй эд зүйл | 4299400 | ш | 1 | 4,290,000 | 4,290,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 3,900,000 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 390,000 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 4,290,000 |

Зураг 30. Эмийн сангийн зардлын баримт



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ПАДААН№:4236209156

ДДТД: 042001004473157093560015310025180
Борлуулагчийн:
ТТД: 2708558
НЭР: Монос-Улаанбаатар
Хаяг: ........
Утас: ........
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......
Банкны IBAN дугаар: undefined

Огноо: 2025-08-19 17:04:46
Худалдан авагчийн:
ТТД: 5115523
Нэр: Тунамалхийц
Хаяг: ........
Утас: ........

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | [0102904] ЦитроМакс №6 (Монос Фарм ХХК) | 62 | ш | 1 | 0 | 46,630 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 42,390.91 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 4,239.09 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 46,630 |

Хүлээн авсан: ........................................ /......................................./
(гарын үсэг) (нэр)

Зураг 31. Эрүүл мэндийн үзлэгийн зардлын баримт


ХААН БАНК

Огноо/Date: 2025-06-17 16:19:34

**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын /Journal No: 31087546

Системийн огноо/System Date: 2025-06-17 15:52:45

| | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number | Нэр/Name | Дүн/Amount | Ханш/Rate |
|---|---|---|---|---|
| Дт | 5011063836 | ТУНАМАЛХИЙЦ | 6,922,100.00 MNT | 1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No 050000; IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 5038045089 | Банкны нэр/Bank Name ХААН БАНК; Нэр/Name ГУРВАНГАЛ ГРУПП | 6,922,100.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-Тунамал хийц ххк 3 н Гал Эрүүл мэндийн үзлэг

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

**Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:**

**Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:**

**Гарын үсэг/Signature:**

**Тамга/Stamp:**

Зураг 32. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөр төлсөн зардлын баримт


МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1240200617075

| | |
|---|---|
| ТД / Регистр: | 67001013236 / 5115523 |
| атвар төлөгчийн нэр: | Тунамалхийц |
| атварын төрөл: | 01030724 - Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлб |
| рьяалах татварын алба: | Баянгол / 20-р хороо |
| лсөн дүн: | 789,939.20 ₮ |
| йлгээний огноо: | 2025-01-30 14:45:26.0 |
| йлгээний утга: | [1240200617075; 67001013236; 5115523; null; Тунамалхийц; 91990042; 501106 ТУНАМАЛХИЙЦ];5000 99999;91990042 |
| варын данс: | НТГ.Ус ашигласны төлбөр - 100200000944 |
| өлтийн хэлбэр: | ХААН банк |